

1. БОННУ-д тусгагдсан арга хэмжээг нэмж тусгасан
2. 5 жилийн нийт зардлыг үндэслэн нэмж тусгаж, барьцаа хөрөнгийг нэмж байршуулав.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	“Аралт худаг шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах”
Төсөл	“Ам Та Тү” ХК
хэрэгжүүлэгчийн	Улсын бүртгэлийн дугаар: 711002059
нэр:	Регистрийн дугаар: 2633086 Дорнод аймаг, Хэрлэн сум 10-р баг /Хэрлэн/, 27-р байр, 49-18 тоот.
Хаяг:	Утас/факс: 99070953

1.2. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Сүүлийн жилүүдэд зах зээл дээр барилгын материалын үнэ, хэрэглээ эрс өсч байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байгаа тул эрдэс баялгаа аж ахуйн эргэлтэд оруулж, улс орныхоо эдийн засгийн чадамжийг өсгөх таатай нөхцөл бүрдэж байгаа энэ боломжийг зүй зохистой ашиглах нь чухал юм.

Энэхүү төсөл хэрэгжсэнээр зүүн бүсэд аж үйлдвэржилт эрчимжиж түүнийг дагаад бусад жижиг дунд үйлдвэрлэл байгуулагдсанаар тухайн орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ, улсын төсвийн орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх зорилт тавьж төслийг боловсруулсан байна.

барилгын материалын, уул уурхайн хөвүүлэн баяжуулах үйлдвэрүүд, замын болон бусад салбарт дараах үр дүнтэй байх болно. Үүнд:


- Дорнод аймагт үйл ажиллагаа явуулж буй алтны үндсэн ордууд болон хөвүүлэн баяжуулах үйлдвэртэй уул уурхайн компаниуд СаО-ын өндөр агууламжтай шохойгоор бүрэн хангагдана.
- Нүүрсний хэрэглээ багасаж, бүтээгдэхүүний өртөг багасана, үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдэж ашиг орлого нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.
- Орчин үеийн шинэ техник технологийг өөрийн оронд нутагшуулснаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.
- Үйлдвэрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуй, газар тариалан, хот суурин газрын цэцэрлэгжүүлэлтэнд үр дүнтэй ашиглах боломж бүрдэнэ.
- Бусад салбарт манай бүтээгдэхүүнийг түүхий эд болгон ашиглах олон шинэ жижиг дунд үйлдвэр байгуулагдахад эхлэл болно.
- Үйлдвэр шинэ технологиор ажилласнаар ажлын байр шинээр бий болох бөгөөд манай бүтээгдэхүүнийг ашиглаж байгуулах үйлдвэрт ч мөн шинэ ажлын байр нэмэгдэх юм.

1.3. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Аралт худаг нэртэй шохойн чулууны орд нь засаг захиргаа харьяаллын хувьд Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт, Чойбалсан хотоос зүүн хойш 71 км, Чойбалсан сумаас хойд зүгт 21 км зайд оршино.

Хүснэгт 1. Аралт худагийн MV-004136 тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицол

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
MV-004136 (26.85 га)	2007-02-12	30	1	114° 48' 4.29"	48° 40' 3.96"
			2	114° 47' 39.3"	48° 40' 3.96"
			3	114° 47' 39.3"	48° 40' 20.97"
			4	114° 48' 4.29"	48° 40' 20.97"



Зураг 1. Аралт худагийн MV-004136 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн байрлал

1.4. ГАЗАР АШИГЛАЛТ, ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай, одоогийн газар ашиглалт: Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт орших MV-004136 тоот тусгай зөвшөөрөлтэй Аралт худаг нэртэй шохойн чулууны 26.85га талбайтай ордыг “Ам Та Тү” ХХК эзэмшдэг.



Зураг 2. Ил уурхайн харагдах байдал



Зураг 3. Шохойн чулууны үйлдвэр




Зураг 4. Ажилчдын кемп

ТЭЗҮ -д тусгасан ил уурхай эцсийн байдлаар газар ашиглалтын төрлийг доор үзүүлээ.

Хүснэгт 2. Газар ашиглалтын төрөл

№	Төрөл	Талбайн хэмжээ, м ²
1	Ухаш	5.4
2	Шимт хөрсний овоолго	0.8
3	Овоолго	4.1
5	Үйлдвэр	2
6	Кемп	0.6
7	ШТС	0
8	Сайжруулсан шороон зам	1.5

Газар ашиглалтын хувьд тусгай зөвшөөрлийн талбайд Ухаш, овоолго, Шимт хөрсний овоолго, сайжруулсан зам зэрэг төрлүүдтэй, нийт талбайн 40 хувь 10.8 га талбайд үйл ажиллагаа явагдахаар ТЭЗҮ-д тусгагдсан байна. Тусгай зөвшөөрлийн талбайн баруун талд Шохой чулууны баяжуулах үйлдвэр болон ажилчдын кемп байрлаж байна.



Зураг 5. Төслийн талбай дахь газар ашиглалт

1.5. АРАЛ ХУДАГИЙН ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРД

Ордын нөөц: Тус ордод хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг 1976 оны 12-р сарын 29-ний өдөр БНМАУ-ын ГУУҮЯ-ны ШУТЗ-ийн хурлаар авч хэлэлцсэн №79 тоот дүгнэлтээр ордын нөөцийг бодитой ($B=748.5$ мян.тн) болон боломжтой ($C=1159.9$ мян.тн) зэргээр $B+C=1908$ мян.тн-оор улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна. Төсөлд ашиглалтын үеийн бохирдлийг 4.11% буюу 76.42 мян.тн, хаягдал 3.31% буюу 59.27 мян.тн байхаар тооцож геологийн бодитой болон боломжтой ($B+C$) зэрэглэлийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан B нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нийт нөөц 1,849.7 мян.тн шохойн чулууг ил уурхайн аргаар олборлохоор байна.

Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 378.4 мян.м³, хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 40.0 мян.тн шохойн чулуу олборлох хүчин чадалтайгаар 47 жилийн хугацаатай ажиллана. Үүнээс эхний 10 жилд 400.0 мян.тн шохойн чулуу олборлон, 65.3 мян.м³ хөрс хуулалт хийхээр төлөвлөжээ.

Хүснэгт 3. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт/Уурхайн 10 жилийн төлөвлөлт/

№	Үзүүлэлтүүд	Тодорхойлолтууд
1	Аж ахуй нэгжийн нэр	“Ам Та Тү” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	711002059
3	Уурхайн нэр	Аралт худагийн шохойн чулууны уурхай
4	Ордын нэр ба тусгай зөвшөөрлийн дугаар	Аралт худагийн шохойн чулууны орд MV-004136
5	Батлагдсан геологийн нөөц	Шохойн чулуу $B=748.5$ мян.тн $C=1159.9$ мян.тн $B+C=1908.4$ мян.тн

6	Ил уурхайн хүрэн дэх геологийн нөөц	B+C=1908.4 мян.тн
7	Ил уурхайн хүрэн дэх үйлдвэрлэлийн нөөц	B+C=1849.7 мян.тн
8	Ашиглах арга ба хугацаа	Ил аргаар ашиглах эхний 47 жил
9	Ашиглах арга ба хугацаа	Ил уурхай: авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглана.
10	Жилийн хүчин чадал	Ил уурхай - Шохойн чулуу олборлолт-40.0 мян.тн - Дундаж хөрс хуулалт – 7.2 мян.м³ - Дундаж шохой гаргалт - 21.49 мян.тн
11	Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд	110 мм диаметртэй өрмийн машин -1ш түрээс 1.2 м³ утгуурын багтаамжтай -1ш түрээс 25 тн даацтай автосамосвал-2ш 3.0м³ утгуурын багтаамжтай утгуурт ачигч-2ш
12	Уурхайн ёроолын түвшин	Ил уурхай 775 м
13	Ажлын доголын өндөр	Хөрс хуулалт 5 м Шохойн чулуу олборлолт 5 м
14	Доголын налуугийн өнцөг	55°
15	Ажлын талбайн өргөн	20 м
16	Замын налуу	80%
17	Цахилгаан хангамж	115 кВт, 150 кВт хүчин чадалтай дизель цахилгаан үүсгүүрээс хангана.

Уурхайн хүчин чадал: Ил уурхайн хүчин чадлыг жилд 40.0 мян.тн шохойн чулуу олборлохоор ТЭЗҮ-д тусгасан байна. Ил уурхайн ажиллах жилийг 46.2 жил тооцон гаргажээ.

1.6. ДЭД БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Барилга, байгууламж: Аралт худгийн шохойн чулууны ордын барилга байгууламжийг үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалтаар тус тусад нь, уурхайн ажиллагсдын хотхоныг уурхайгаас баруун хойд зүгт 0.5 км зайд барьж байгуулахаар төлөвлөсөн байна. Уурхайн хотхонд уурхайн захиргааны байр, хоолны газар, халуун ус, ахуй үйлчилгээний байр, уурын зуух, засварын газар, авто граж, сэлбэг материалын агуулах зэрэг барилга байгууламжууд байх ба мөн шатах тослох материалын агуулах автомашины зогсоол зэрэг багтаж байна. Барилга байгууламж болон үйлдвэрлэлийн зориулалттай объектуудыг сэндвичин угсармал хавтан хийцтэй, сэлбэг материалын агуулах зэрэгт чингэлэг ашиглана.

Дулаан хангамж: Аралт худгийн уурхай нь жилд 300 хоног ажиллах ба сэрүүний улиралд ажиллагсдын тосгон болон уурхайн захиргаа, засварын газар зэрэг барилга байгууламжийг нам даралтын бага оврын уурын зуух ажиллуулан дулаанаар хангана. Уурын зуухны сарын хэрэглээнд 7 тн нүүрс түлэх шаардлагатай гэж үзвэл жилд 21 тн нүүрс хэрэглэнэ. Шаардлагатай нүүрсийг Адуунчулууны уурхайгаас түрээсийн авто тээврээр худалдаж авахаар тусгажээ.

Усан хангамж: Өөрсдийн гүний худгаар хангана.

Цахилгаан хангамж: Шохой чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг BF V165 маркийн дизель цахилгаан үүсгүүрээс, дэд бүтэц болон засварын газрын цахилгаан хэрэглэгчдийг BF-C125 маркийн дизель цахилгаан үүсгүүрээс хангана.

Зам тээвэр: Тус орд нь ойролцоох сум суурин газруудтай ердийн хээрийн орон нутгийн чанартай шороон замаар холбогдоно. Үйлдвэрийн болон уурхайн дотоод замууд нь байнгын усалгаа арчилгаатай уурхайн зориулалтай сайжруулсан шороон зам байна.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Тээврийн хэрэгслийн яндангаас утаа болон хорт хий ялгарах	Дизель түлш ашигладаг дотоод шаталт хөдөлгүүрүүд болон машинуудыг ашиглаагүй үед сул асаалттай байлгахгүй байх, шаардлага хангахгүй байгааг нь шинэчлэх	тээврийн хэрэгслийн хөдөлгөөн үргэлжлэх нийт талбай	ширхэг	Үйл ажиллагааны зардлаар			Жилд 1 удаа	Байгаль хамгаалах тухай хууль Агаарын тухай хууль, MNS ISO 14064.1.2015 Хүлэмжийн хий - Нэгдүгээр хэсэг - Байгууллагын төвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж; Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06) MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 4585:2025 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага
2.	Уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үед эвдэгдсэн газруудаас салхи ба техникийн нөлөөгөөр тоос үүсэх	Уурхайн хөрс тээврийн технологийн замд тээврийн хэрэгслийн нөлөөгөөр үүсэх тоос, тоосонцрыг бууруулах, аюулгүй ажиллах нөхцөлийг хангах, усалгаа хийх	Ил уурхай, хөрсний овоолго	тн		500,000		Тогтмол хугацаанд	
3.	Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Хурдны хязгаар 40км/ц-аас хэтрэхгүй байхаар хязгаарлах зааварчилгаа өгч, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна ашиглагдаж буй замууд	ширхэг		500,000		2026	
4.	Төслийн усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Харьяалагдах сав газрын захиргаанаас ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Усан хангамжийн эх үүсвэр	Төг	Гэрээнд заасны дагуу төлбөр төлөгдөнө	Жил бүрийн үйл ажиллагааны зардалд тусган төлнө.		2026	Усны тухай хууль, 4.3, 30.1.1, 30.1.2 зүйл заалт Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичгийн загварыг шинэчлэн батлах тухай (БОАЖС-ын 2018 оны А/376 дугаар тушаал)
		Усны чанар, нөөцийн мониторинг хийх		удаа	ОХШХ-т тусгасан			ОХШХ-т тусгасан давтамжаар	Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам (БОНХС-ын 2014 оны А-86 дугаар тушаалын хавсралт)

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.		Төслийн ашиглалтын нөлөөгөөр эвдрэлд орсон газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Нөхөн сэргээх шаардлагатай ашиглалтад өртсөн газрууд		Нөхөн сэргээлтийн зардалд тусгасан			1 удаа	- MNS 5915:2008 Байгаль орчин. Уул Төслийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал - БОНХ-ийн сайд 2015 А-138 Уул төслийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал - MNS 5914 : 2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Монгол Улсын стандарт - MNS 5917 : 2008 Уул Төслийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт Техникийн ерөнхий шаардлага, - MNS 5918 : 2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
6.	Шохойн чулуу олборлолт, үйлдвэрлэл дагалдах барилга байгууламж, дотоод тээврийн зам, ашиглалтад өртсөн газрын гадарга, хэвлий байгалийн төрх байдлаа бүр мөсөн алдах	Үйлдвэрлэлийн талбайг хэсэгчлэн хашаалж, талбайд хайрган эсвэл хатуу хүчилт хийх	Үйлдвэрийн талбай		1.000,000.0			2026	
Сөрөг нөлөөг бууруулах нийт зардал, мян.төг						2,000,000.0 төгрөг			

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ,	1 жилийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД								
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд - Кемп болон үйлдвэрийн талбайг хашаалан хойд талаар салхины хамгаалалтын ойн зурвас байгуулах - Орон нутагтай хамтран ажиллах	Улиас 2-3 настай суулгац-Агч Нарс	ш	150	500,000.0		2026 он	Монгол улсын засгийн газрын 2021 оны 11-р сарын 17-ний өдрийн 350 дугаар тогтоол "тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай
2	Нөлөөллийн бүс болон төсөл хэрэгжиж буй багийн айл өрхүүдэд жил бүр тухайн бүсийн байгалийн нөхцөлд тохирсон мод, бут, сөөгний суулгацыг олгон, эхний жилд мэргэжлийн багийн бүрэлдэхүүнээр өөрсдөө тарьж, ургамалжуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүний дараагаар жил бүр тогтмол арчилгаа, хамгаалалт, нэмж суулгах ажлыг зохион байгуулж, нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ургамлан нөмрөгийг тогтвортой сайжруулах нөхцөл бүрдүүлнэ.	Улиас 2-3 настай суулгац-Агч Нарс Олон наст ургамал	ш	100	-	500,000.0	2026 он	
Нийт зардал мян.төг						1,000,000.0		

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ /БОНБУТХ-3.1.11/.

Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт байрлах “Аралт худгийн шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд шууд болон шууд бус байдлаар өртөх талбайг ArcGIS 10.4.1. програм ашиглан зураглавал 415 га талбай шууд болон шууд бус нөлөөлөлд өртөх ба эрчмээр нь ангилвал 112 га талбай их эрчимтэй, 58 га дунд эрчимтэй, 245 га талбай бага эрчимтэй нөлөөлөлд өртөхөөр байна.

Ордтой холбоотойгоор бэлчээрийн газарт үзүүлэх үлдэгдэл нөлөөллийн асуудлыг авч үзэж, шийдвэрлэхийн тулд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаагаар бэлчээрийн ургамлын бүлгэмдлүүдийн биологийн олон янз байдлын үнэ цэнийг нөхөн хамгаалвал зохино.

Энэ төслийн хувьд Аймгийн байгаль орчны газраас өгсөн зөвлөмж шийдвэрийн дагуу дараах арга хэмжээнүүдийг 2030 он хүртэл авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардал, гүйцэтгэгч байгууллагын менежментийн зардлаас бусад зардлыг нийт зардалд тооцоогүй болно.

Итгэлцүүр дээр тулгуурласан нийт ДХ ажилд шаардагдах нэгж= 1181

Дүйцүүлэн хамгааллын зардал = \$5;

Дүйцүүлэн хамгааллын нийт зардал = \$5905

Энэ зардлын тооцоо нь TNC-н дүйцүүлэн хамгааллын программ хангамжийн тусламжтайгаар тооцоолсон ба үүнд дүйцүүлэн хамгаалах ажилд 5905 доллар буюу ойролцоогоор 22 сая төгрөг зарцуулахаар байна.

Дүйцүүлэн хамгааллын суурь зардлыг TNC-ийн MDT Desktop программ хангамжийн тусламжтайгаар тооцоход жилд 5,905 ам.долларын өртөгтэй гэж гарсан бөгөөд энэ нь экологийн алдагдлыг нөхөхөд шаардагдах онолын доод түвшний зардлыг илэрхийлнэ. Харин төслийн хүрээнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төслийн хэрэгжүүлэгч өөрийн хөрөнгөөр газар дээр нь бодитоор хэрэгжүүлэх бөгөөд 5 жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд мониторинг, материал, ажиллах хүч болон бусад холбогдох үйл ажиллагааны зардлыг хамруулан нийт 29.0 сая төгрөгөөр тооцож, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үйл ажиллагааны зардалаар зохицуулагдахаар тусгав.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн нөхцөл байдлаас шалтгаалан шаардлагатай зардлыг нэмэн гаргаж болно. Учир нь дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх үед тооцогдоогүй зардлыг тооцоонд оруулах боломжтой.

Хүснэгт 2 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Үлийн цагаан оготнын тоо толгойг хянах, бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор махчин шувуудын үүрлэх орчин бий болгох, тэднийг ангуучлах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор суух объект бий болгох	Хиймэл үүр, суултуур хийх	Үлийн цагааны тархалт, нягтшил өндөр газарт	үүр, суултуур хийх	1,500.000	1,500 000	шинэ технологийг ашиглан үйл ажиллагаа жигдрэх үед	Стандарт үгүй хэдий ч хиймэл үүрийг 2 м орчим өндөр орой нь битүү, шувууд орж гарах онгорхой хэсэгтэй байх,
Нийт зардал:				1,500,000.0				

ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Цаашид барилга байгууламж нэмж барих, өргөтгөх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй. Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны Яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

Уурхайн үйл ажиллагааны явцад санамсаргүйгээр археологи ба палеонтологийн олдворууд олдож болзошгүй тул үйл ажиллагааны явцад санамсаргүй олдворууд олдсон тохиолдолд Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ын дагуу дагаж мөрдөн ажиллана.

Хүснэгт 3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл олборлох ажлаа зогсоож энэ тухай, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Үйл ажиллагаа явуулах талбайд	-	Үйл ажиллагааны зардлаар		Тухайн үед нь шийдэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журам

ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	Төслийн бүх ажилтан, ажиллагсдад хамаарна. Бүх шатны ажиллагсдын ажил үүргийн хуваариар тодорхойлогдсон байна.	Үйл ажиллагааны зардлаар			2026 он	-
2.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зөрчил	Ажиллагсдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх	Төслийн бүх ажилчид					Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Нэр томьёо тодорхойлолт” MNS 4967:2000
		эцсийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг хийлгэсэн байх, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг үйл ажиллагаанд ашиглах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд					
				Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх Анхан шатны тусламжийн эм, тариа багажийг хяналтын өрөө эсвэл ажлын байруудын аль тохиромжтой газар байрлуулах	Төслийн бүх ажилчид	-		
3.	Галын аюул	Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг байрлуулах	Галын хор, элс, хүрз гэх мэт туслах материал бүхий галын сарай байршуулах	Үйл ажиллагааны зардлаар				Гал түймрээс хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага MNS 5566 :2005
Осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх нийт, мян.төг								-

ДОЛОО. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Хог хаягдлын төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Энгийн хог хаягдал	- Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах гэрээг жил бүр сунган мөрдөн ажиллах	Төслийн талбай	хоногт 3.2 кг, сард 96 кг, жилд 25.6 тн		200,000	Үйл ажиллагааны зардлаар	5 жилийн турш	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага” (БОАЖС-ын 2018 оны А/443 дугаар тушаал).
2.	Ариутгал халдваргүйжүүлэлт	- Уурхайн кемп,00, хогийн цэг зэргүүдэд ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Уурхайн аюултай хог хаягдал үүсэх цэг бүрт	тн					
3.	Шингэн хог хаягдал	Бохирын цооног, шугамын эвдрэл гэмтлийн тогтмол хяналт	Төслийн талбай	цэг	Дотоод төлөвлөлтөөр		2026-2030 он сар бүр		“Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам” Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох журам БОАЖС-ын 2018 оны 01 сарын 30 өдөр №А/18
Нийт				200,000.0					

НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР


Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Ам та тү” ХХК -ийн явуулж буй үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. ОХШХ нь БОМТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Ам та тү” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

Хүснэгт 6. Хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн Тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1. АГААРЫН ЧАНАР								
1.	Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , PM _{2.5} , PM ₁₀ CO ₂), дуу чимээний хэмжилт хийлгэх	- Уурхай орчим - Үйлдвэр/Бүтлүүр - Үйлдвэр/Эргэлдэх зуух/ - Ажилчдын кемп орчим	Жилд 1 удаа	4	50,000+60 000/техникчийн зардал/	260.0	Байгаль орчин хэмжилзүйн лаборатори	- MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
2. УСНЫ ЧАНАР								
1	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	- Унд ахуйн хэрэгцээг хангаж буй өөрийн худаг - Ойролцоох малчны худгаас хяналтын дээж	Жилд 2 удаа	4	45,000.0	180.0	“Геоаналатик” ХХК-ийн тарифаар тооцсон	- MNS 4586:2024 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, - MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны үс. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ - MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Усны бохирдлын хяналт хийх	- Унд ахуйн хэрэгцээг хангаж буй өөрийн худаг - Ойролцоох малчны худгаас хяналтын дээж		4	85,000.0	340.0		
3. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ								
1	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	1. Уурхай орчим 2. Үйлдвэр орчим 3. Хяналтын цэг	Жилд 2 удаа	6	80,000	480.0	“Геоаналатик” ХХК-ийн тарифаар тооцсон	- MNS 5850 : 2019, Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”, - MNS 3297 : 2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
2	Хөрсний бохирдлын шинжилгээ /хүнд металл/	Үйлдвэр орчим		6	45,000	270.0		
		Хогийн цэг						
3	Хөрсний бохирдлын шинжилгээ /эрүүл ахуй/	Уурхай орчим		6	25,000	150.0		
		Ажилчдын кемп						
		Хогийн цэг орчим						
		Нүхэн жорлон орчим						
4	Цөмийн цацрагийн шинжилгээ Изотопын идэвх, Бк/кг / ²²⁶ RA, ²³² Th, ⁴⁰ K, ¹³⁷ Cs /, Элементийн агуулалт / U, г/тн, Th, г/тн, K, % /,	Шохойн чулуу	Жилд 1	1	70,000	70.0	- Дээжийн жин хамгийн багадаа 1000 гр байх - Дээжийг цэвэр сав, уутанд хийж битүүмжилсэн байх	- MNS 6240:2011, “Цацрагийн хамгаалалт. Цөмийн цацрагийн тунгийн хязгаар” - MNS 5631:2006
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх 5 жилийн гүйцэтгэлийн зардал								1,750,000.0 төг



Зураг 6. Орчны хяналт шинжилгээний цэгүүд

ЕС. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь																				Хариуцсан албан тушаалтан	тайлбар	
			2026 он				2027 он				2028 он				2029 он				2030 он						
			I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV			
1.	Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын харилцааг зохицуулах дотоод дүрэм, журамтай болох	“Ам та тү” ХХК-аас зохицуулах				+																	Удирдах албан тушаалтан + асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Шаардлагатай тохиолдолд удирдах дээд байгууллагат асуудлыг тавьж шийдвэрлүүлэх хүртэл арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.	
2	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10’ зүйлийн дагуу байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх																								
	Нийт	Дотоод төлөвлөлтөөр																							

АРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ БАТЛУУЛАХ ХУВААРЬ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн дүүргийн иргэдийн хуралд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийж байх шаардлагатай болно.

Хүснэгт 8. Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ–ий хэрэгжилтийг хэлэлцүүлэх байгууллага	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
1	Сүмбэр багийн иргэдийн нийтийн хурал	БОМТ хэрэгжилтийг гаргаж, төлөвлөгөөний танилцуулга хийх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жилд 1 доошгүй удаа	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт танилцуулж санал авах	Үйл ажилла-гааны зардлаар	Сүмбэр
2	Аймгийн байгаль орчны газар	БОМТ биелэлтийг 3-аас доошгүй хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлэх		Аймгийн байгаль орчны газар
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	БОМТ биелэлтийн тайлан, дүн болон дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг цахимаар	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн 12 дугаар сарын 30-ний дотор	Дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулах		Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн, мян.төг					-		

АРВАН ХОЁР. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДАЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний зарим арга хэмжээний зардлыг тусгайлан тооцоогүй нь тухайн ажлуудыг төслийн үндсэн үйл ажиллагааны тогтмол зардлын хүрээнд хэрэгжүүлэх боломжтой, мөн тухайн нөхцөл шаардлага (нүүлгэн шилжүүлэлт, түүх, соёлын өвийн хамгаалалт, ослын нөхөн төлбөр зэрэг) үүсээгүйтэй холбоотой болно. Иймд давхардсан санхүүжилтээс зайлсхийж, зөвхөн нэмэлт санхүүжилт шаардлагатай арга хэмжээнүүдэд зардлыг тооцон тусгасан.

БОННУ-ний нэмэлт тодотголын хүрээнд хэрэгжүүлэх БОМТ-ний нийт зардлыг 5 жилийн хугацаанд 58,375,000 төгрөгөөр тооцоолсон. Бөгөөд 2026 оны БОМТ-ний зардалд 9,875,000.0 төгрөгийг тусгасан. 2026 оны байгаль орчныг хамгаалах нийт төсөв **9,950,000** төгрөг байхаар тусгав.

Хүснэгт 9. БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал

№	БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	2026	Нийт тооцсон зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2,000,000.0	12,500,000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,000,000.0	5 жилийн нийт зардалд 7,125,000 төгрөг төлөвлөсөн боловч 2026 онд төслийн үйл ажиллагаа бүрэн хүчин чадалдаа хүрч тогтворжоогүй байх тул тухайн жилд бага хэмжээний төсөв тусгав.
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1,500,000.0	5 жилийн нийт зардалд 29,000,000 төгрөг төлөвлөсөн боловч 2026 онд төслийн үйл ажиллагаа жигдрээгүй тул тухайн жилд зардлыг хязгаарлаж, бага хэмжээгээр тусгав.
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах, осол эрсдлийн зардлууд нь нөхцөл үүссэн тохиолдолд холбогдох жилийн байгаль хамгаалах төлөвлөгөөний хүрээнд санхүүжихээр тусгасан.
5	Түүх соёлын өвийг хамгаалах	-	
6	Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө	-	
7	Хог хаягдлын менежментийг зохион байгуулах	200,000.0	1,000,000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,750,000.0	8,750,000.0
9	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	3,500,000.0	2024 онд аудит хийлгэж байсан тул хуулийг хугацаа болсон тул энэ онд хийхээр оруулав.
10	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	-	-
Нийт зардал		9,950,000.00	5 жилийн БОМТ-нд 58,375,000.0/2026 онд төлөвлөсөн зардал 9,950.0/